



МОНГОЛ УЛСЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/150

Улаанбаатар хот


Ажлын уян хатан цагийн хуваарь тогтоох
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улс орон даяар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нар тодорхойгүй хугацаагаар ажил хаялт зарласантай холбогдуулан хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ тушаалын хавсралтад заасан 0-12 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг ажил хаялт зогстол долоо хоногийн ажлын нэг өдөр нэгжийнхээ даргатай тохиролцсоны үндсэн дээр зайнаас ажиллуулах, бусад өдрүүдэд дотоод зохион байгуулалт хийж албан хаагчдад 2 цагийн цалинтай чөлөө олгосугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мөрдүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Бат-Эрдэнэд даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.БАЯРАА

1525021069